



ОРЛОГЫН ТАТВАРЫГ ДАВХАР НОГЦУУЛАХГҮЙ БАЙХ,
ТАТВАР ТӨЛӨХӨӨС ЗАЙЛСХИЙХИЙГ СЭРГИЙЛЭХ ТУХАЙ
МОНГОЛ УЛС, БҮГД НАЙРАМЦАХ СОЛОНГОС УЛСЫН
ХӨӨРӨНДҮЙН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар,

Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар,

Орлогын татварыг давхар ногцуулахгүй байх, татвар төлөхөөс
зайлсхийхийг сэргийлэх тухай хэлэлцээр байгуулж,

Дараах зүйлийг хэлэлцэн тохиров.

Нэгдүгээр зүйл

Хамаарах этгээд

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу тэцгээ-
рийн аль нэгний нутаг дэвсгэрт байнга оршин суугч этгээдэд ха-
маарна.

Хоёрдугаар зүйл

Хамаарах татвар

I. Энэхүү Хэлэлцээрт мөрдөж байгаа дараах татварууд ха-
маарна:

а/Монголын хувьд:

1/Хүн амын орлогоос хураах албан татвар;

2/Хоршоо, компани, байгууллагын орлогын татвар;
/цаашид "Монголын татвар" гэнэ/

б/Солонгосын хувьд:

1/Орлогын татвар;

2/Корпорацийн татвар;

3/Оршин суугчийн татвар;

/цаашид "Солонгосын татвар" гэнэ/

2.

2. Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш шинээр буюу хуучны оронд бий болсон татварууд нь эдүгээ мөрдөж буй татварууцтай үндсэндээ адил буюу төстэй байвал энэхүү Хэлэлцээрт мөн хамаарна.

Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллага нь өөрийн орны холбогдох татварын хуульд орсон аливаа зарчмын өөрчлөлтийн талаар нөгөө талцаа мэдэгдэнэ.

Гуравдугаар зүйл
Ерөнхий тодорхойлолт

I. Энэхүү Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол:

- а/"Монгол" гэж Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийг хэлнэ;
- б/"Солонгос" гэж БНСУ-ын нутаг дэвсгэр болон олон улсын эрх зүйн дагуу БНСУ-ын хуулиар түүний бүрэн эрхийг тогтоосон буюу тогтоож болох нутгийн устай залгаа бөгөөд далайн ёроол, хэвлий болон тэдгээрийн байгалийн нөөц баялагийг энд дурдсан бүрэн эрхийн дагуу БНСУ ашиглаж болох аливаа газрыг хэлнэ;
- в/"Хэлэлцэн тохирогч нэг Улс", "Хэлэлцэн тохирогч нөгөө Улс" гэж тухайн заалтын утгаас хамааран Монгол буюу Солонгосыг хэлнэ;
- г/"Татвар" гэж тухайн заалтын утгаас хамваран Монголын буюу Солонгосын татварыг хэлнэ;
- д/"Этгээд" гэж хувь хун, компани буюу бусад байгууллагыг хэлнэ;
- е/"Компани" гэж татвар ногдуулах үндэстэй аливаа байгууллага буюу түүнтэй адилтгах хуулийн этгээдийг хэлнэ;



3.

ж/"Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгж", "Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгж" гэж тухай тухайн улсад байнга оршин суугч этгээцийн эрхэлцэг аж ахуйн нэгжийг хэлнэ;

з/"Харьяат" гэж

1/Хэлэлцэн тохирогч Улсын харьяат бүх хувь хүн,

2/Хэлэлцэн тохирогч Улсад мөрдөгдөж байгаа хуулийн цагуу эрхээ эцэлж буй бүх хуулийн этгээд, нөхөрлөл, холбоодыг хэлнэ;

к/"Слон улсын тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч аль нэг Улсын аж ахуйн нэгжээс хөлөг онгоц буюу нисэх онгоцоор хийх аливаа тээврийг хэлнэ. Харин Хэлэлцэн тохирогч нөгөө Улс цахь цэгүүдийн хооронд хийх тээврийн үйл ажиллагаа үүнд үл хамаарна;

л/"Эрх бүхий албан тушаалтан" гэж Сангийн сайд буюу түүний эрх бүхий төлөөлөгчийг хэлнэ.

2.Энд тодорхойлогдоогүй аливаа нэр томъёог Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрээр зохицуулагдаж буй татвартай холбогдол бүхий тухайн Хэлэлцэн тохирогч Улсын хуульд зааснаар ойлгоно.

Дөрөвдүгээр зүйл

Байнга оршин суугч

1.Энэхүү Хэлэлцээрт "Хэлэлцэн тохирогч аль нэг Улсад байнга оршин суугч" гэж өөрөө байнга оршин сууж, удирдах, толгойлох байгууллага нь байнга байрлаж байгаа, мөн үүнтэй адилтгах бусад нөхцөлөөр тэр Улсын хууль тогтоомжийн цагуу тухайн Улсад татвар



4.

төлөх үүрэгтэй аливаа этгээдийг хэлнэ. Гэхцээ энэ заалт зөвхөн тухайн Улсын эх үүсвэрээс орлого олж, эл Улсад татвар төлөх үүрэг хүлээж буй аливаа этгээдэд үл хамаарна.

2. Энэхүү зүйлийн I дүгээр заалтын дагуу Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга оршин суугч хувь хүний статусыг цараах байдлаар тодорхойлно:

а/ байнга амьдардаг орон гэр нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно. Хэрэв хувь хүн нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэртэй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түүний хувийн ба эдийн засгийн харилцаа /амин чухал ашиг сонирхол/ нь илүү ойр дөт байгаагаар нь тэндхийн байнга оршин суугч гэж тооцно;

б/ хэрэв түүний ашиг сонирхол аль Улсад зонхилж байгааг нь тодорхойлох боломжгүй эсвэл тухайн этгээд нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга амьдардаг орон гэргүй бол Хэлэлцэн тохирогч аль Улсад түр орогнох байртай байгаагаар нь тэр Улсад байнга оршин суугч гэж тооцно;

в/ хэрэв хувь хүн нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь түр орогнох байртай эсвэл алинд нь ч байргүй бол түүнийг Хэлэлцэн тохирогч аль Улсын харьяалаар нь тухайн Улсын байнга оршин суугч гэж үзнэ;

г/ хэрэв хувь хүн нь Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алины харьяат эсвэл алиных нь ч харьяат биш бол асуудлыг Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэх шийдвэрлэнэ.



5.

3. Энэхүү зүйлийн I дүгээр заалтын дагуу хувь хүнээс бусад этгээд Хэлэлцэн тохирогч хоёр Улсын аль алинд нь байнга байрладаг бол түүний удирдан захирах байгууллага нь Хэлэлцэн тохирогч аль Улсад байрлаж байгаагаар нь тэр Улсад байнга байрлаж байна гэж үзнэ. Эргэлзээтэй тохиолдолд Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд асууцлыг хэлэлцэн тохиролцох үнцсэн дээр шийдвэрлэнэ.

Тавцугаар зүйл

Байнгын төлөөний газар

1. Энэхүү хэлэлцээрт "Байнгын төлөөний газар" гэж аж ахуйн нэгж өөрийн үйл ажиллагаагаа бүхэлд нь бууу хэсэгчлэн явуулдаг тодорхой газрыг хэлнэ.

2. "Байнгын төлөөний газар" гэдэгт тухайлбал:

- а/ удирдах газар;
- б/ салбар байгууллага;
- в/ албан байр;
- г/ үйлдвэр;
- д/ тасаг;

е/ уурхай, газрын тос, байгалийн хий болон байгалийн бусад ашигт малтмал олборлож буй газар орно.

3. Зөвхөн I2 сараас дээш хугацаагаар үргэлжлэх барилга байгууламж, угсралт суурилалтын ажил, барилгын талбайг байнгын төлөөний газар гэж тооцно.

4. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад тодорхойлсон "Байнгын төлөөний газар" гэдэгт дараах үйл ажиллагаа үл хамаарна:



6.

а/аж ахуйн нэгж зөвхөн өөрийн бараа, таваарыг халгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор аливаа байгууламж ашиглах;

б/аж ахуйн нэгж зөвхөн халгалах, үзэсгэлэнд тавих, нийлүүлэх зорилгоор бараа, таваар нөөцлөх;

в/аж ахуйн нэгж өөр бусад аж ахуйн нэгжээр зөвхөн боловруулалт хийлгэх зорилгоор бараа, таваар нөөцлөх;

г/аж ахуйн нэгжид зориулан бараа, таваар зөвхөн худалдан авах, мэдээлэл цуглуулах зориулалттай үйл ажиллагаа явуулдаг тодорхой байр ашиглах;

д/аж ахуйн нэгжийн бэлтгэх, туслах чанарын аливаа үйл ажиллагаа явуулах зорилгоор тодорхой байр ашиглах;

е/энэ заалтын "а"-гаас "д"-д заасан үйл ажиллагааг зөвхөн бэлтгэх болон туслах чанарын ажлын зориулалтаар хослуулан эрхлэх байр ашиглах.

5.Энэхүү зүйлийн I ба 2 дугаар заалтыг үл харгалзан 6 дугаар заалтад хамаарах бие цаасан эрх бүхий төлөөлөгчөөс бусад этгээд Хэлэлцэн тохирогч нэг Улсад Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж гэрээ байгуулах эрх эцэлдэг бол уг аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч Улсад байнгын төлөөний газартай гэж үзнэ.Гэхдээ уг этгээдийн үйл ажиллагаа 4 дүгээр заалтад дурдсан үйл ажиллагаагаар хязгаарлагдан улмаар энэ ажиллагааг явуулж буй байр нь дээрх заалтын дагуу байнгын төлөөний газар болж чадахгүй тохиолдолд уг аж ахуйн газрыг байнгын төлөөний газартай гэж үзэхгүй.

6.Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад брокер, ерөнхий комиссын төлөөлөгч, бие цаасан

эрх бүхий бусад төлөөлөгчдөөр дамжуулан өөрийн тогтсон чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байвал түүнийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнгын төлөөний газартай гэж үзэх үндэс болохгүй. Гэхдээ тийм төлөөлөгчийн үйл ажиллагаа нь бүхэлдээ буюу цийлэнхдээ уг аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс хийгдэж байгаа бол тэр нь энэхүү заалтын бие даасан эрх бүхий төлөөлөгч гэдэгт үл хамаарна.

7.Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга байрладаг компани нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга байдаг эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад үйл ажиллагаагаа /байнгын төлөөний газраар дамжуулан буюу бусад аргаар/ явуулдаг компанийг хянадаг эсвэл түүний хяналтанд байдаг нь эдгээр компанийг бие биеийнх нь байнгын төлөөний газар гэж үзэх үндэс болохгүй.

Зургадугаар зүйл

Үл хөдлөх хөрөнгөнөөс орох орлого

1.Хэлэлцэн тохирогч нэг Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөнөөс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч орлого /түүний дотор хөдөө аж ахуй буюу ойн аж ахуйгаас олсон орлого/ олбол уг орлогоос энэхүү хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улс татвар авч болно.

2."Үл хөдлөх хөрөнгө" гэдгийг тухайн хөрөнгө байрлаж буй Хэлэлцэн тохирогч Улсын хуульд заасны дагуу тодорхойлно.Аль ч тохиолдолд уг нэр томъёонд үл хөдлөх хөрөнгөц дагалдах өмч, хөдөө аж ахуйн болон ойн аж ахуй дахь мал, амьтан, тоног төхөөрөмж, газар оролцсон өмчийн талаарх хуулиар олгогдсон эрх, бусдын үл хөдлөх хөрөнгийг эзэмшин ашиглах эрх, уурхай, ашигт малтмалын орд, рашаан ус болон байгалийн бусад баялгийн хөдөлгөөнт болон тогтмол талбөрийн эрхийг багтаана.Харин хөлөг онгоц,завь, нисэх онгоц нь үл хөдлөх хөрөнгөц үл тооцогдоно.



8.

3. Энэхүү зүйлийн I дүгээр заалт нь үл хөдлөх хөрөнгийг шууд ашиглах, бусдад түрээслүүлэх эсвэл бусад аль нэг хэлбэрээр ашиглах замаар олсон орлогод хамаарна.

4. Энэхүү зүйлийн I болон 3 дугаар заалт нь аж ахуйн нэгжийн үл хөдлөх хөрөнгө, түүнчлэн бие даасан хувийн үйлчилгээнд ашигласан үл хөдлөх хөрөнгөнөөс олсон орлогод хамаарна.

Долдугаар зүйл

Аж ахуйн үйл ажиллагааны ашиг

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхдээ тэнд байрладаг байнгын төлөөний газраар дамжуулаагүй тохиолдолд зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс ашигт нь татвар ногдуулна. Хэрэв аж ахуйн нэгж нь дурдсан үйл ажиллагааг байнгын төлөөний газраар дамжуулан явуулбал уг аж ахуйн нэгжийн ашгийн зөвхөн тухайн байнгын төлөөний газарт хамаарах хэсэгт Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын нутагт байрладаг өөрийн байнгын төлөөний газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй тохиолдолд уг байнгын төлөөний газар нь төлөөлж буй аж ахуйн нэгжтэйгээ бүрэн бие даасан байдлаар харилцаж адил буюу төстэй үйл ажиллагааг адил буюу төстэй нөхцөлд эрхлэн явуулснаар олж болох байсан ашгийг энэхүү зүйлийн 3 дугаар заалтын дагуу уг байнгын төлөөний газрын ашиг гэж Хэлэлцэн тохирогч Улс аль аль нь үзнэ.

3. Байнгын төлөөний газрын ашгийг тодорхойлохдоо аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулахад тус байнгын төлөөний газраас байрлах байгаа Хэлэлцэн тохирогч Улс болон бусад улсад зарцуулсан аж ахуйн болон захиргааны зардлыг хасч тооцно.



9.

4. Аж ахуйн нэгж нь байнгын төлөөний газраар цамжуулан бараа таваарыг зөвхөн еэртөө худалдан авсан бол түүний төлөө уг байнгын төлөөний газрыг ашиг олсонц үл тооцно.

5. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудад нийцүүлэн байнгын төлөөний газарт хамаарах ашгийг тодорхойлохдоо тогтсон аргачлалыг өөрчлөх ноцгой шалтгаан байхгүй бол түүнийг цаашид үргэлжлүүлэн хэрэглэнэ.

6. Хэрэв аж ахуйн үйл ажиллагааны ашиг нь энэхүү Хэлэлцээрийн бусад зүйлц тусгайлан тодорхойлсон төрлийн орлогыг агуулсан бол тэдгээр зүйлийн заалтыг мөрдөхөд энэхүү зүйлийн заалтууд үл нөлөөлнө.

Наймдугаар зүйл

Усан болон агаарын замын тээвэр

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжээс олон улсын тээвэрт хөлөг онгоц болон нисэх онгоцоор тээвэр хийж олох ашигт тухайн Улс нь л татвар ногдуулна.

2. Энэхүү зүйлийн I дүгээр заалт нь картель, хамтын аж ахуй буюу олон улсын тээврийн удирдах албаны үйл ажиллагаанд оролцож олсон ашигт мөн хамаарна.

3. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжээс олон улсын тээвэрт усан болон агаарын тээвэр хийж буй тохиолдолд хэрэв энэ нь Монголын аж ахуйн нэгж бол энэхүү аж ахуйн нэгж нь Солонгост нэмэгдсэн өртгийн татвараас чөлөөлөгдөх бөгөөд хэрэв энэ нь Солонгосын аж ахуйн нэгж бол Солонгост нэмэгдсэн өртгийн татвартай адилтгах аливаа татвараас чөлөөлөгдөх боловч түүнийг цаашид Монголын тал ногцуулж болно.



Ю.

Есдүгээр зүйл Хоршсон аж ахуйн нэгжүүд

1. Хэрэв:

а/Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгж Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт бузу хөрөнгөнд шууд им уу шууд бусаар оролцдог бол;

б/тодорхой этгээдүүд Хэлэлцэн тохирогч нэг Улсын болон Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын аж ахуйн нэгжийн аль алиных нь удирдлага, хяналт бузу хөрөнгөнд шууд им уу шууд бусаар оролцож байгаа бол;

Тэдгээр хоёр аж ахуйн нэгжийн хооронд тогтсон худалцаа, санхүүгийн харилцааны нөхцөл нь бие даасан аж ахуйн нэгжүүдийн хоорондын харилцааны нөхцөлөөс ялгаатай байсны улмаас тухайн аж ахуйн нэгж олох ёстой амгаа олоогүй байсан ч түүнийг олоход тооцож зохих журмын дагуу татвар ногдуулна.

2. Хоёр аж ахуйн нэгжийн хоорондын харилцаа нь бие даасан аж ахуйн нэгжийн хоорондын харилцааны нөхцөлтэй нийцэх байх тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжээс өөрийн Улсаа татвар төлөх ёстой амгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улс өөрийн аж ахуйн нэгжийн ашигт оруулан татвар ногдуулсан байвал Хэлэлцэн тохирогч нөгөө Улс энэхүү амгаас авах татварын хэмжээнд зохих зохицуулалт хийнэ. Ийм зохицуулалт хийхдээ энэхүү Хэлэлцээрийн бусад заалтуудыг харгалзан үзэх бөгөөд шаардлагатай бол Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд харилцан зөвлөлдөнө.

Аравдугаар зүйл

Дивиденд

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга байрладаг компаниас



II.

Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч хувь хүнд төлж буй дивидендэд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхцээ дивиденд төлж буй компани байнга оршдог Хэлэлцэн тохирогч нэг Улс тухайн дивидендэд өөрийн хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулж болох боловч дивиденд авагч этгээд нь түүний жинхэнэ эзэмшигч нь бол ногдуулах татварын хэмжээ нь дивидендийн нийт дүнгийн 5 хувиас хэтрэхгүй байна. Энэхүү заалт нь тухайн компанийн дивиденд агуулсан ашигт ногдуулах татварт үл хамаарна.

3. Энэхүү зүйлд тусгагдсан "дивиденд" гэсэн нэр томъёо нь хувьцааны ногдол ашиг, уурхайн хувьцаа, үүсгэн байгуулагчийн хувьцаа, бусад эрх буюу ашигт өрийн нэхэмжлэлээс бусад хэлбэрээр оролцох эрхээс үүсэх орлого болон түүнтэй адилтгах бусад орлого, түүнчлэн хуваарилалт хийж буй хуулийн этгээд байнга оршдог Хэлэлцэн тохирогч Улсын хууль зүйн дагуу хувьцааны орлоготой адилтган татвар ногдуулдаг бусад орлогыг илэрхийлнэ.

4. Хэрэв дивидендийн жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршдог бөгөөд дивиденд төлөгч компани байрладаг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнгын төлөөний газар буюу бие даасан хувийн үйлчилгээ эрхэлдэг товлосон газраар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг ба дивидендийн эрх хэрэг цээрээ энэ байнгын төлөөний газар буюу товлосон газарт шууд хамааралтай бол I ба 2 дугаар заалтыг баримтлахгүй. Энэ тохиолдолд 7 буюу 14 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга байрладаг компани Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ашиг буюу орлого олж байвал Хэлэлцэн тохирогч нөгөө Улс уг компанийн төлж буй дивидендэд татвар ногдуулахгүй байж болно. Гэхцээ уг компаниас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлж байгаа дивиденд Хэлэлцэн

тохирогч нөгөө Улс дахь байнгын төлөөний газар буюу төвлөсөн газартай шууд хамааралтай бол татвар ногдуулж болно. Харин цивиленц төлөгдсөн ч гэсэн тэрээр хувиарлагдаагүй ашиг нөгөө Улсад буй болсон ашиг орлогоос бүхэлцээ буюу хэсэгчлэн бүрдэж байлаа ч гэсэн компаний хувиарлагдаагүй ашигт ногдох татварыг уг компаний хувиарлагдаагүй ашигт ногдуулахгүй.

Арван нэгдүгээр зүйл

Хүү

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсад бий болж, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд төлсөн хүүд Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхцээ хүү бий болсон Хэлэлцэн тохирогч нэг Улс өөрийн хуулийн дагуу уг хүүд татвар ногдуулж болох боловч хэрэв уг хүүг авагч нь түүний жинхэнэ эзэмшигч нь бол ногдуулах татварын хэмжээ нийт хүүний 5 хувиас хэтрэхгүй байна.

3. Энэхүү зүйлийн 2 дугаар заалтыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч нэг Улсад бий болсон бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын Засгийн газар, орон нутгийн эрх барих байгууллага, төв банк болон энэхүү Засгийн газарт харьяалагдах аливаа санхүүгийн байгууллага буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын оршин суугчийн олсон хүү, Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын төв банк буюу Засгийн газарт харьяалагдах аливаа санхүүгийн байгууллага, орон нутгийн эрх барих байгууллагуудыг оролцуулан Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын Засгийн газар ашигт өрийн нэхэмжлэлийг баталгаажуулж шууд бусаар санхүүжүүлж байгаа бол хүүд Хэлэлцэн тохирогч нэг Улс татвар ногдуулахгүй.

4.3 дугаар заалтын зорилгод нийцүүлэн "Төв банк болон Засгийн газарт бүрэн харьяалагддаг санхүүгийн байгууллагууд" гэх



13.

а/Монголын хувьц:

—Монгол улсын Засгийн газарт харьяалагцдаг санхүүгийн байгууллагуудыг хэлэх бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсуудын Засгийн газрын хооронд тухай бүр тэдгээрийг тохиролцож болно.

б/Солонгосын хувьц:

1/Солонгосын банк;

2/Солонгосын экспорт-импортын банк;

3/Солонгосын хөгжлийн банк;

4/БНСУ-н Засгийн газарт бүрэн харьяалагцдаг санхүүгийн бусад байгууллагуудыг хэлэх бөгөөд Хэлэлцэн тохирогч Улсуудын Засгийн газрын хооронд тухай бүр тэдгээрийг тохиролцож болно.

5. Энэхүү зүйлд тусгагддаг буй "хүү" гэсэн нэр томъёонд барьцаагаар баталгаажуулсан эсэх, зээлдэгчийн ашигт оролцох эрхтэй эсэхийг ул харгалзан бүх төрлийн өрийн нэхэмжлэлээс үүссэн орлого ялангуяа улсын зээлэг, бусад үнэт цааснаас орох орлого мөн тэдгээрийн урамжууллын орлого орно. Харин төлбөр тооцоо хэмжээгээр торгууль нь энэхүү зүйлд цурдсан хүү гэж тооцогдохгүй.

6. Хэрэв хүүг жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суухын зэрэгцээ Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнгын төлөөний газраараа цамжуулан хүү нь буй болох газраа аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг хийгээд тухайн улсад байрладаг товчлон газраа бие цаасан хувийн үйлчилгээ явуулдаг бол бол байнгын төлөөний газар буу товчлон газартай холбогдолтой хүү нь төлөгдсөн ашигт өрийн нэхэмжлэл дээрх I ба 2 дугаар зүйлийн заалтад хамаарахгүй. Энэ тохиолдолд 7 буюу I4 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

7. Хэлэлцэн тохирогч нэг Улс өөрөө буюу орон нутгийн эрх барих байгууллага уг Улсын байнга оршин суугч нь хүүг төлөх бол тэр хүүг тухайн Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн

тохирогч Улсын байнга оршин суугч эсэхийг үл харгалзан, хүүг төлөгч этгээд Хэлэлцэн тохирогч Улсад байнгын төлөөний газар эсвэл товлосон газартай бөгөөд үүнтэй холбогдон хүү төлөгдөж, уг хүүг байнгын төлөөний газар эсвэл товлосон газар төлөх бол цээрх байнгын төлөөний газар эсвэл товлосон газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч Улсад хүү бий болсон гэж үзнэ.

8. Хэрэв хүү төлөгч болон хүү жинхэнэ эзэмшигчийн хооронд мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан алигт ерийн нэхэмжлэлд төлсөн хүүний хэмжээ нь ийм харилцаа байхгүй байсан үед хүү төлөгч болон жинхэнэ эзэмшигч хоёр хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэрч байвал энэ зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнд хамаарна. Энэ тохиолдолд хүүний төлбөрийн илхү гарсан зөргүүд Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу энэ хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан татвар ногдуулна.

Арван хоёрдугаар зүйл

Шан /роялти/

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсад бий болж байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугчид төлөгдсөн шан /роялти/ Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Улсад бий болж байгаа шан /роялти/ тухайн Улсын хуулийн дагуу татвар ногдуулж болох боловч уг шанг /роялти/ авагч нь түүний жинхэнэ эзэмшигч нь бол ийнхүү ногдуулж буй татвар нь шангийн /роялти/ нийт хэмжээний 10 хувиас хэтрэхгүй байна.

3. Энэхүү зүйлд хэрэглэгдэж буй шан /роялти/ гэсэн нэр томъёонд уран зохиолын хэвлэн нийтлэх эрх, урлагийн болон шинжлэх ухааны бүтээл, түүний дотор уран сайхны кино, бусад кино, радио

болон телевизийн нэвтрүүлэгт зориулсан бичлэг, патент, бараан тэмдэг, дизайн буюу загвар төлөвлөгөө, нууц томъёолол буюу процессыг ашигласан буюу ашиглах эрх эдэлсэн, эсвэл үйлдвэрлэл, худалдаа буюу шинжлэх ухааны тоног төхөөрөмж, үйлдвэр, худалдаа буюу шинжлэх ухааны туршлагатай холбогдсон мэдээллийг ашигласан буюу ашиглах эрх эдэлсний төлөө төлж буй бүх төрлийн төлбөрийг хамааруулна.

4. Хэрэв шанг /роялти/ жинхэнэ эзэмшигч нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршдог боловч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс цахь байнгын төлөөний газраар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд тэнд энэхүү шан /роялти/ бий болж байгаа эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад оршдог товлосон газраар дамжуулан бие даасан хувийн үйлчилгээ хийдэг, түүнчлэн шан /роялти/ авах эрх буюу хөрөнгө нь хэрэг дээрээ энэхүү байнгын төлөөний газар эсвэл товлосон газарт шууд хамааралтай бол энэхүү зүйлийн I ба 2 дугаар заалт хэрэглэгдэхгүй. Ийм тохиолдолд 7 буюу I4 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

5. Эрхийн шан /роялти/ төлөгч нь Хэлэлцэн тохирогч нэг Улсын Засгийн газар, орон нутгийн эрх барих байгууллага буюу уг Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч бол уг шанг /роялти/ тухайн Улсад бий болсон гэж үзнэ. Нөгөө талаар Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суудаг эсэхийг үл харгалзан шан /роялти/ төлөгч этгээд уг Хэлэлцэн тохирогч нэг Улсад шан /роялти/ төлөх үүрэг бүхий болон төлж байгаа байнгын төлөөний газар ба товлосон газартай бол энэхүү шан /роялти/ нь уг байнгын төлөөний газар ба товлосон газар оршиж байгаа Хэлэлцэн тохирогч нэг Улсад бий болсон гэж үзнэ.

6. Шан /роялти/ төлөгч болон түүнийг жинхэнэ эзэмшигчийн хооронд, мөн түүнчлэн тэдгээрийн болон ямар нэгэн хөндлөнгийн этгээдийн хоорондын онцлог харилцаанаас шалтгаалан ашиглаж хэрэглэх, эрх авах ба мэдээллийн хувьд төлөгдсөн шангийн хэмжээ нь ийм харилцаа байхгүй тохиолдолд түүнийг төлөгч ба жинхэнэ

эзэмшигч хоёрын хоорондоо тохиролцож болох байсан хэмжээнээс хэтэргэл энэхүү зүйлийн заалтууд зөвхөн тохиролцож болох байсан хэмжээнц хамаарна. Энэ тохиолдолд төлбөрийн илүү гарсан зөрүүг энэхүү Хэлэлцээрийн бусад заалтыг харгалзан Хэлэлцэн тохирогч Улс бүр өөрийн хуулийн дагуу татвар ногдуулна.

Арван гуравдугаар зүйл

Хөрөнгө борлуулсны орлого

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байгаа бөгөөд энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд хамаарах үл хөдлөх хөрөнгийг борлуулснаас олоон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь байнгын төлөөний газрын үйл ажиллагаанд ашиглагддаг хөрөнгийн зарим хэсэг болсон хөдлөх хөрөнгийг борлуулснаас буку Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугчаас Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад бие цаасан хувийн үйлчилгээ явуулах зорилгоор ашиглаж буй товлосон газарт харьяалагдах хөдлөх хөрөнгийг борлуулснаас түүний дотор ийм байнгын төлөөний газар /дангаар нь эсвэл бүх аж ахуйн нэгжийн нь хамт/ буку ийм товлосон газрыг борлуулснаас тус тус орох орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

3. Олон улсын тээвэрт ашиглагдаж буй хөлөг онгоц, нисэх онгоцыг борлуулснаас буку эдгээр хөлөг онгоц, нисэх онгоцоор хийх үйлчилгээнд хамрагдах хөдлөх хөрөнгийг борлуулснаас олоон орлогод ийм тээврийн хэрэгслийг ашиглаж буй тухайн аж ахуйн нэгж байрладаг Хэлэлцэн тохирогч Улс л татвар ногдуулна.

4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад байрладаг үл хөдлөх хөрөнгөнөөс шууд ба шууд бусаар гол төлөв бүрддэг бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьцааг худалдаж борлуулснаас олох орлогод уг Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулж болно.

5. Энэхүү зүйлийн 1,2,3 болон 4-д зааснаас бусад аливаа хөрөнгийг борлуулснаас олох орлогод зөвхөн уг хөрөнгийг борлуулсан этгээдийн байнга оршин суудаг Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулж болно.

Арван дөрөвдүгээр зүйл

Бие даасан хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суугч нь мэргэжлийн үйлчилгээ буюу бие даасан шинжтэй бусад үйл ажиллагаа явуулсны дунд олсон орлогод хэрэв энэ байнга оршин суугч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад өөрийн үйл ажиллагааг явуулах зорилгоор тогтмол ашигладаг товлосон газаргүй бол зөвхөн энэхүү Хэлэлцэн тохирогч нэг Улс татвар ногдуулна. Хэрэв байнга оршин суугч нь ийм товлосон газартай бол түүний орлогын зөвхөн энэ товлосон газарт хамаарах хэсэгт нь нөгөө Улс татвар ногдуулж болно.

2. "Мэргэжлийн үйлчилгээ" гэдэг нэр томъёонд ялангуяа шинжлэх ухаан, уран зохиол, урлаг, боловсрол буюу багшлах бие даасан үйл ажиллагааг, түүнчлэн эмч, хуульч, инженер, архитекторч, шүдний эмч болон нягтлан бодогч нарын бие даасан үйл ажиллагааг хамааруулна.

Арван тавдугаар зүйл

Бие даасан бус хувийн үйлчилгээ

1. Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил үйлчилгээ эрхлээгүйгээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугчийн ажил хийж авсан цалин хөлс болон түүнтэй адилтгах бусад орлогод 16, 18, 19, 20 ба 21 дүгээр зүйлц заасанчлан зөвхөн Хэлэлцэн тохирогч нэг Улс татвар ногдуулна. Хэрэв ажил эрхлэлтийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад гүйцэтгэж байгаа бол тэрхүү ажил эрхлэлтээс олсон орлогод уг Улс татвар ногдуулж болно.

2. Энэхүү зүйлийн I-д заасныг үл харгалзан Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ажил эрхэлснээс олсон орлогод Хэлэлцэн тохирогч нэг Улс дор дурдсан нөхцөлд татвар ногдуулна:

а/орлого авагч нь тухайн хуанлийн жилд нийтдээ 183 өдрөөс илүүгүй хугацаагаар Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байсан бол;

б/орлогыг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суудаггүй этгээд өөрөө эсвэл энэ этгээдийн нэрийн өмнөөс олгосон бол;

в/орлогыг хөлслөгч этгээдийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь байнгын төлөөний газар буюу төвлөсөн газар нь олгодоггүй бол.

3. Энэхүү зүйлийн өмнөх заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч аль нэг Улсын аж ахуйн нэгжээс олон улсын тээвэр хийж буй хөлөг онгоц буюу нисэх онгоцод гүйцэтгэсэн ажлын орлогод зөвхөн тухайн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

Арван зургадугаар зүйл

Захирлуудын шагнал

Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь компанийн захирлуудын зөвлөлийн гишүүний хувьд авсан шагнал болон түүнтэй адилтгах бусад төрлийн шагналд зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулж болно.

Арван долдугаар зүйл

Жүжигчид ба тамирчид

I.Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суугаа театр, киноны жүжигчин, радио буюу телевизийн жүжигчин, хөгжимчин буюу



19.

тамирчин Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хувийн тоглолт хийж олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улс энэхүү Хэлэлцээрийн 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан татвар ногдуулж болно.

2. Урлагийнхан буюу тамирчид хувийн тоглолт явуулж олсон орлого нь хөндлөнгийн этгээдэд ногдож байгаа тохиолдолд тоглолт явагдсан тухайн Хэлэлцэн тохирогч Улс энэхүү Хэлэлцээрийн 7, 14 ба 15 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан уг орлогод татвар ногдуулж болно.

3. Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суугч жүжигчин буюу тамирчнаас Хэлэлцэн тохирогч Улсуудын Засгийн газрын хооронд байгуулсан соёлын солилцооны тусгай төлөвлөгөөний дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад хийсэн тоглолтоос олсон орлогод Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулахгүй бөгөөд үүнд энэхүү зүйлийн 1 ба 2 дугаар заалт ч үл хамаарна.

Арван наймдугаар зүйл

Тэтгэвэр

Хэлэлцэн тохирогч Улсад байнга оршин суугч этгээдийн өмнө нь хийж байсан ажлын тэтгэвэр болон түүнтэй ажилтгах бусад тэтгэмжид энэхүү Хэлэлцээрийн 19 дүгээр зүйлийн 2 дугаар заалтын дагуу зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс л татвар ногдуулна.

Арван есдүгээр зүйл

Төр, засгийн алба

1. а/Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний орон нутгийн эрх барих байгууллагаас тухайн Улс буюу түүний орон нутгийн нь эрх барих байгууллагад алба хашиж байсны нь хувьд олох тэтгэврээс бусад төлбөрт тухайн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна;

б/гэхдээ уг хувь хүн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад алба хашиж байгаа ба тэнд байнга оршин суугч бол дараах тохиолдолд түүнд олгох төлбөрт зөвхөн уг Хэлэлцэн тохирогч нөгөө Улс л татвар ногцуулна. Үүнд:

1. Тэр улсын харьяат буюу эсвэл
2. Гагцхүү алба хаших үүднээс тэр улсын байнга оршин суугч болоогүй бол.

2.а/Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний орон нутгийн эрх барих байгууллагын бүрдүүлсэн сангаас тухайн улс буюу түүний орон нутгийн эрх барих байгууллагад алба хашиж байсны нь хувьд олгосон аливаа тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

б/гэхдээ уг хувь хүн нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч бөгөөд тэр Улсын харьяат бол цэр цурдсан тэтгэвэрт зөвхөн Хэлэлцэн тохирогч нөгөө Улс татвар ногдуулна.

3. Хэлэлцэн тохирогч Улс буюу түүний орон нутгийн эрх барих байгууллагаас аж ахуйн үйл ажиллагаа явуулахтай холбоотой алба хашсан төлөө олгосон төлбөр, тэтгэврийн хувьд энэхүү хэлэлцээрийн 15, 16 ба 18 дугаар зүйлийг хэрэглэнэ.

4. Энэхүү зүйлийн 1 ба 2-т орсон заалтууд нь цор цурдсан байгууллагуудаас олгож буй төлбөр буюу тэтгэвэрт хамаарна:

а/Монголын хувьд:

-Засгийн газраас эрх олгосны дагуу Засгийн газрын байгууллагын үүрэг гүйцэтгэж буй бусад байгууллагуудыг хамаарах бөгөөд эдгээрийн талаар Хэлэлцэн тохирогч хоёр Улсын Засгийн газрууд үе үе Хэлэлцэн тохирч болно.



21.

б/Солонгосын хувьд:

-Солонгосын банк, Солонгосын экспорт-импортын банк, Солонгосын хөгжлийн банк, Хуцалцааг хөхүүлэн цэмжих корпорац болон Засгийн газраас эрх олгосны цагуу Засгийн газрын байгууллагын үүрэг гүйцэтгэж байгаа бусад байгууллагуудыг хамаарах бөгөөд эдгээрийн талаар Хэлэлцэн тохирогч хоёр Улсын Засгийн газрууд үе үе хэлэлцэн тохиролдрж болно.

Хорьдугаар зүйл

Оюутан

Хэлэлцэн тохирогч нэг Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч байсан буюу оцоо хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нэг Улсад гагцхүү суралцах буюу цацлага хийх зорилгоор ирсэн оюутны буюу цацлага хийгчийн өөрийн хангамж, сургалт, цацлагадаа зориулан авсан буюу олсон дараах төлбөрийг буюу орлогыг Хэлэлцэн тохирогч нэг Улсын татвараас чөлөөлнө. Үүнд:

а/Хэлэлцэн тохирогч нэг Улсын гаднах эх үүсвэрээс авч байгаа төлбөр;

б/Засгийн газар буюу шинжлэх ухаан, боловсрол, соёлын буюу татвараас чөлөөлөгдөх бусад байгууллагаас олгох тэтгэмж, тэтгэлэг буюу шагнал.

Хорин нэгдүгээр зүйл

Профессор багш нар

Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад ирэхийнхээ өмнө Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч байсан буюу оцоо хэвээр байгаа бөгөөд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын Засгийн газраас ашиг арилжааны бус байгууллага гэж тооцдог их, цээд болон бусад аливаа

сургуульд буюу тэдэнтэй ажилтгах боловсролын байгууллагад зөвхөн хичээл заах буюу эрдэм шинжилгээний ажил хийхээр эсвэл хоёуланг нь хавсран хийхээр ирж байгаа хувь хүн Хэлэлцэн тохирогч нэг Улсад анх ирсэн өдрөөсөө эхлэн 2 жил хүртэлх хугацаанд хичээл заасны буюу эрдэм шинжилгээний ажил хийсний хөлсөнд авах орлогыг Хэлэлцэн тохирогч нэг Улсын татвараас чөлөөлнө.

Хорин хоёрдугаар зүйл

Бусад орлого

1. Хэлэлцэн тохирогч Улсын байнга оршин суугч олж байгаа боловч энэхүү Хэлэлцээрийн өмнөх зүйлүүдэд хөндөгцөөгүй аливаа орлогод зөвхөн Хэлэлцэн тохирогч Улс татвар ногдуулна.

2. Хэрэв орлого ологч нь Хэлэлцэн тохирогч нэг Улсын байнга оршин суугч байх Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь байнгын төлөөний газраар дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа буюу Хэлэлцэн тохирогч нөгөө Улс дахь товлосон газраар дамжуулан уг улсын цотор бие цаасан хувийн үйлчилгээ эрхэлж байгаа бөгөөд түүний эрх буюу хөрөнгөтэй холбогдон олсон орлого нь дээрх байнгын төлөөний газар буюу товлосон газартай шууд холбоотой бол 6 дугаар зүйлийн 2 дугаар заалтад тодорхойлогдсон үл хөдлөх хөрөнгийн орлогоос бусад орлогод энэхүү зүйлийн I дүгээр заалт үл хамаарна. Энэ тохиолдолд 7 буюу I4 дүгээр зүйлийн аль тохиромжтойг хэрэглэнэ.

Хорин гуравдугаар зүйл

Давхар татвараас чөлөөлөх талаар

1. Монголын байнга оршин суугчийн хувьд давхар татвараас дараах байдлаар чөлөөлнө:

-Монголын байнга оршин суугч Солонгост орлого олж байвал энэхүү Хэлэлцээрийн дагуу уг орлогоос Солонгост төлбөл зохих татварын дүнг тухайн байнга оршин суугчийн нийт орлогод ногдуулах Монголын татварын дүнгээс хасч тооцно. Гэхдээ уг татварын хөнгөлөлтийн хэмжээ нь Монголын татварын хууль, дүрмийн дагуу тухайн орлогод ногдвол зохих Монголын татварын хувь хэмжээнээс хэтрэхгүй байна.

2. Солонгосын байнга оршин суугчийн хувьд давхар татвараас цараах байдлаар чөлөөлнө:

-Монголын доторх эх үүсвэрээс олсон орлогод Монголын хууль болон энэхүү Хэлэлцээрийн дагуу Монгол Улс татвар ногдуулбал дээрх орлогод Солонгосын татвараас шууд буку бууруулах замаар хөнгөлөлт үзүүлэх бөгөөд гэхцээ энэ нь Солонгосоос бусад аль нэг орны дотор Солонгосоос ногдуулах татварыг хөнгөвчлөх тухай Солонгосын татварын хуулийн заалтуудад захирагдана. Гэхдээ Монгол доторх эх сурвалжаас олсон орлогод үзүүлсэн татварын хөнгөлөлт нь Солонгосын татварын хуулийн дагуу бүх орлогод ногдуулах Солонгосын татварын нийт хэмжээнээс хэтрэхгүй байна.

Хорин дөрөвдүгээр зүйл

Ялгаварлан гацуурхах явдал гаргахгүй байх

1. Хэлэлцэн тохирогч нэг Улсын харьяат Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад татвар төлөх болон түүнтэй холбоотой бусад шаарцлагын хувьд Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын харьяатаас татварын адилгүй буку илүү хундралтэй нөхцөлд оруулахгүй байна. Энэхүү заалт нь Хэлэлцээрийн I дүгээр зүйлийн заалтуудыг үл харгалзан Хэлэлцэн тохирогч Улсуудын аль нэгэнд нь, эсвэл алинд нь ч оршин сууцаггүй этгээцэд мөн адил хамаарна.

2. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжийн Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байрладаг байнгын төлөөний газраас татвар төлөх нөхцөлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад түүнтэй ажилтгах төрлийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцөлөөс дор байлгаж болохгүй. Энэ заалт нь Хэлэлцэн тохирогч нэг Улс нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугчдыг иргэний эрх, гэр бүлийн хариуцлагын хувьд өөрийн байнга оршин суугчдын ажил татвараас чөлөөлөх, хөнгөлөх, багасгах эрх эдлүүлэх ёстой гэсэн утгаар хэрэглэгдэхгүй.

3. Энэхүү Хэлэлцээрийн 9 дүгээр зүйлийн I дүгээр заалт, II дүгээр зүйлийн 8 дугаар заалт, I2 дугаар зүйлийн 5 дугаар заалтыг хэрэглэхээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжийн татвар ноглуулах ашгийн хэмжээг тодорхойлохдоо тухайн аж ахуйн нэгжээс Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад байнга оршин суугч этгээдэд талж буй хүү, шан /роялти/ болон бусад төлбөрийг бууруулна. Гэхдээ энэ нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад байнга оршин суугч этгээдэд талж байгаа ийм төлбөрийн нөхцөлтэй ажил байна.

4. Хэлэлцэн тохирогч нэг Улсын аж ахуйн нэгжийн хөрөнгийг Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын байнга оршин суугч нэг буюу хэсэг этгээд шууд буюу шууд бусаар бүхэлд нь эсвэл хэсэгчлэн өмчлөх буюу хянаж байвал уг аж ахуйн нэгжийг Хэлэлцэн тохирогч нэг Улс өөрийн ажил төрлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн татвар төлөх нөхцөл болон түүнтэй холбогдох бусад шаардлагатай ажил бус буюу тэдгээрээс илүү хүндрэлтэй байдалд оруулахгүй.

5. Энэ зүйлийн заалтууд нь 2 дугаар зүйлийн заалтуудыг үл харгалзан бүх төрлийн татварт хамаарна.

Хорин тавцугаар зүйл
Харилцан тохиролцох журам

1. Хэлэлцэн тохирогч хоёр Улс буюу тэдгээрийн аль нэг нь энэхүү Хэлэлцээрт заагцаагүй татвар ногдуулах арга хэмжээ авсан гэж хэрэв аливаа этгээд үзвэл тэрээр гомцлоо эдгээр улсын дотоодын хууль тогтоомжийн заалтууцыг үл харгалзан өөрийн байнга оршин суугаа Хэлэлцэн тохирогч Улсын эрх бүхий байгууллагад буюу хэрэв гомцол нь 24 дүгээр зүйлийн I дүгээр заалттай холбоотой бол өөрийн харъяалагддаг Хэлэлцэн тохирогч Улсын мөн тийм байгууллагад гаргаж болно.

Энэхүү Хэлэлцээрт заагцаагүй татвар ногдуулах үйл ажиллагаа явуулж байна гэж анх мэдсэнээс хойш 3 жилийн дотор гомцлоо гаргах ёстой.

2. Гомцлыг нотолж, хангалттай шийдвэр гаргах боломжгүй бол тухайн эрх бүхий байгууллага нь энэхүү Хэлэлцээрт заагцаагүй татвар ногдуулахгүй байх зорилгоор Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын эрх бүхий байгууллага харилцан тохирч асуудлыг шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Аливаа тохиролцоог Хэлэлцэн тохирогч Улсуудын дотоодын хууль тогтоомжийн цаг хугацааны аливаа хязгаарлалтыг үл харгалзан хэрэгжүүлнэ.

3. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэглэхэд үүсэх аливаа хүндрэлтэй болон эргэлзээтэй асуудлуудыг харилцан тохиролцох журмаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Мөн түүнчлэн энэхүү Хэлэлцээрт заагцаагүй орлогыг давхар татвараас чөлөөлөх асуудлаар тэд хамтран зөвлөлдөж болно.

4. Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагууд нь өмнөх заалтуудын дагуу тохиролцох үүднээс шууд харилцах болно. Хэрэв тохиролцоонд хүрэхийн тулд биечлэн уулзах санал солилцох шаардлагатай байвал Хэлэлцэн тохирогч Улсуудын эрх бүхий байгууллагуудын



26.

төлөөлөгчдөөс бүрэлдсэн комиссоор дамжуулан ийнхүү санал солилцох уулзалтыг зохион байгуулах болно.

Хорин зургадугаар зүйл

Мэдээлэл солилцох

1. Татвар ногдуулалт нь энэхүү Хэлэлцээрт харшлаагүй үед Хэлэлцэн тохирогч хоёр Улсын эрх бүхий байгууллагууд энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын талаарх хоёр Улсын дотоодын хууль тогтоомж болон уг Хэлэлцээрийн заалтуудыг биелүүлэхэд шаардагдах мэдээллийг харилцан солилцож байна.

Мэдээлэл харилцан солилцох нь I дүгээр зүйлээр үл хязгаарлагдана. Хэлэлцэн тохирогч Улс нь хүлээн авсан мэдээллийг дотоодын хууль тогтоомжийн дагуу нууцалж, зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын асуудалтай холбоо бүхий этгээдүүд, эрх барих байгууллагуудад /шүүх, захиргааны байгууллагыг оролцуулан/ мэдэгдэх эрхтэй. Тэдгээр этгээд, эрх барих байгууллагууд нь уг мэдээллийг зөвхөн энэхүү Хэлэлцээрт хамрагдах татварын хэмжээг тодорхойлох, хураан дайчлах, албадах, ял шийтгэл оноох, даван заалдахыг шийдвэрлэх зорилгод ашиглана. Түүнчлэн тэд цээрх мэдээллийг олон нийтийн шүүхийн протокол, шүүхийн шийцвэрт ашиглаж болно.

2. Энэхүү зүйлийн нэгд орсон заалт нь Хэлэлцэн тохирогч нэг Улсад цараах үүргийг хүлээлгэж байгаагаар тайлбарлаж хэрхэвч болохгүй:

а/Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль, захиргааны хэм хэмжээнд харшлах захиргааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх;

б/Хэлэлцэн тохирогч Улсуудын хууль буюу захиргааны ердийн үйл ажиллагааны дагуу олж үл болох мэдээллээр хангах;



27.

в/Хэлэлцэн тохирогч Улсуудын хуцалцаа, арилжаа, бизнес, аж үйлдвэр, мэргэжлийн нууц алдагдуулах мэдээ болон задруулбал нийгмийн хэв журамд харшлах мэдээллээр хангах.

Хорин долдугаар зүйл

Дипломат ба консулын төлөөлөгчдийн газрын ажилтнууд

Энэхүү Хэлэлцээр нь олон улсын эрх зүйн ерөнхий хэм хэмжээ буюу тусгай Хэлэлцээрийн заалтуудын цагуу дипломат ба консулын ажилтнуудын эдлэх санхүүгийн эрх цархыг үл хөндөнө.

Хорин наймдугаар зүйл

Хүчин төгөлдөр болох тухай

Энэхүү Хэлэлцээрийг хоёр Улс соёрхон баталж, батламж жуух бичгийг аль болох ойрын үец*Сейн*....-д солилцоно. Хэлэлцээр нь батламж жуух бичиг солилцоноос хойш гуч цахь өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээр дараах байцлаар үйлчилж эхэлнэ. Үүнц:

а/байнга оршин суугч бус этгээдүүдийн орлогод ногдуулсан татвар болон хөнгөлөлтийн хувьд Хэлэлцээрт гарын үсэг зурсан жилийн I дүгээр сарын I-нээс эхлэн үйлчилж эхэлнэ.

б/бусад татварын хувьд Хэлэлцээрт гарын үсэг зурсан жилийн I дүгээр сарын I болон түүнээс хойш эхлэх татварын жилүүцэц энэ нь хамаарна.

Хорин есдүгээр зүйл

Дуусгавар болох хугацаа

Энэхүү Хэлэлцээр нь хугацаагүй мөрдөгдөх боловч Хэлэлцэн тохирогч аль нэгэн Улс уг Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш 5 цахь жилээс түүнийг цуцлах тухайгаа хуандийн жилийн 6 дугаар



28.

сарын 30-ны өдөр бузу түүнээс өмнө Хэлэлцэн тохирогч нөгөө Улсад
дипломат шугамаар бичгээр мэдэгцэж болно.

Энэхүү тохиолдолд уг Хэлэлцээр нь цараах байцлаар хүчин тө-
гөлдөр байхаа болино. Үүнд:

а/байнга бус оршин суугч этгээдүүдийн орлогод ногдуулсан
татвар болон хөнгөлөлтийн хувьд мэдэгдэл өгсөн жилийн
цараах хуанлийн жилийн I дүгээр сарын I-нээс эхлэн
дуусгавар болно;

б/бусад татварын хувьд мэдэгдэл өгсөн жилийн цараах хуан-
лийн жилийн I дүгээр сарын I болон түүнээс хойш эхлэх
татварын жилээс эхлэн дуусгавар болно.

Тус тусын Засгийн газраас зохих ёсоор эрх олгогдсон дор дурд-
сан төлөөлөгчид дээр дурдсаныг нотолж энэхүү Хэлэлцээрт гарын үсэг
зурав.

Энэхүү Хэлэлцээрийг 1992 оны 4 дугаар сарын 17-ны өдөр
Улаанбаатар хотноо монгол, солонгос, англи гурван хэл дээр тус
бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд бүх эх нь адил хүчинтэй.

Тайлбар хийх явцад санал зөрөлдвөл англи эх хувийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ

БҮГД НАЙРАМЦАХ СОЛОНГОС УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ